Булган аймгийн Баян-Агт сумын Эрүүл мэндийн төв нь харьяа нутаг дэвсгэрийн хүн амд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлэх эрүүл мэндийн төрийн үйлчилгээний байгууллага юм.

#### **Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар:**

Үйл ажиллагаа: Тайлант онд эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд үйлчлүүлэгчийн биеийн байдалд үнэлгээ өгөх, хянах, эрүүл мэндийг дэмжих, аливаа өвчнөөс урьдчилан сэргийлэхэд орчин үеийн болон уламжлалт анагаах ухаанд тулгуурлан эмнэлгийн анхан шатны тусламжийг үзүүлэхэд чиглэхийн зэрэгцээ 9 зорилтын хүрээнд 66 ажил төлөвлөн 92.6%-тай хэрэгжүүлсэн байна.

Эрхэм зорилго: “ хүн амын эрт илрүүлгийн хамрагдалтыг 90 хувьд хүргэж, өвчлөлийг эрт үед оношилж, хавдрын шалгаант нас баралтыг бууруулах, эрүүл мэндийн ажилчдын ур чадварыг дээшлүүлж, чанартай тусламж үйлчилгээ үзүүлэх, нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг шинэлэг хэлбэрээр зохион байгуулах” гэсэн зорилтыг хэрэгжүүлэн ажилласан байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

#### **Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар:**

Тэшиг сумын Эрүүл мэндийн төв нь үйл ажиллагаандаа Эрүүл мэндийн тухай хууль, ЭМДҮЗ-өөс гаргасан тогтоолууд, НЭМ-ийн тухай хууль, эм эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, төсвийн тухай хууль, төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, хөдөлмөрийн тухай хууль, НББ-ийн тухай хууль, татварын тухай хууль, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, нийгмийн даатгалын тухай хууль, шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол, Засгийн газрын 2019 оны 5, 6, 7 дугаар тогтоол, Засгийн газрын 2024 оны 39 дугаар тогтоол, Засгийн газрын 2024 оны 238 дугаар тогтоол, Сангийн сайдын 2024 оны А/50 дугаар тушаал болон эрүүл мэндийн салбарт мөрдөгдөж буй хууль эрх зүйн акт, тогтоол, шийдвэр тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад дүрэм, журам стандартыг мөрдлөг болгон ажиллаж байна.

Төсвийн шууд захирагч батлагдсан төсөвт үндэслэн зарлагын гүйлгээг цахимаар хянаж баталгаажуулснаар дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол сумын төрийн сан холбогдох санхүүгийн баримт материал, гэрээ, гүйцэтгэлийн баримт бичиг, зарлагын гүйлгээг хянан баталгаажуулан ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, НББ-д мөрддөг хууль тогтоомжид орсон өөрчлөлт Засгийн газрын 238 тогтоолоор “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээ”-г шинэчлэн тогтоож 2025 оны 01 сарын 1-ний өдрөөс мөрдлөг болгосон, Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам" батлах тухай А/03 дугаар тушаалууд болно.

#### **Байгууллагын дотоод хяналтын талаар:**

Байгууллагын удирдлагын баг болон дотоод хяналтын багаас хэрэгжүүлж буй төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна. Байгууллагын дотоод хяналтын баг нь 2025 оны

01 сарын 06-ны өдрийн А/02 тоот тушаалаар 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдсан ба “Дотоод хяналт, шалгалт зохион байгуулах журам”-ыг боловсруулан ажиллаж байна. Байгууллагын Дотоод хяналтын багийн ажиллах журмыг Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 6.4 заасны дагуу МУЗГ-ын 2011 оны 11 сарын 09 өдрийн 311 тогтоолыг үндэслэн боловсруулан, батлан, мөрдөн ажиллахаас гадна байгууллагын үйл ажиллагаанд "ДОТООД ХЯНАЛТ, ШАЛГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ"-ыг боловсруулан ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, НББ-д мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй хэвийн явагдсан байна.

Дотоод хяналтын баг нь 2025 онд хийх ажлын график төлөвлөгөө, цаашид хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, сургалтын төлөвлөгөөг оны эхэнд гаргаж батлуулсан ба хяналт шалгалт хийсэн ажлын дүгнэлт, илтгэх хуудсыг бичин баримтжуулан ажилласан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөө багатай байна гэж үнэллээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Булган аймгийн Баян-агт сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

#### **Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар:**

Баян-агт сумын Эрүүл мэндийн төв нь Булган аймгийн Засаг даргын 2020 оны 09 дүгээр сарын 29-ны өдрийн А/424 дугаар захирамжаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ыг мөрдөж ажиллаж байна. Энэ нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч Эрүүл мэндийн тухай хууль, шинэчлэгдсэн журам, гүйцэтгэл, үр дүнд суурилсан төсвийн төлөвлөлт, санхүүжилтийн бүртгэлийн талаар тусгагдаагүй учраас тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан шинэчлэх шаардлага үүсэж байна.

Нягтлан бодох бүртгэлийн хөтлөлтийг Си Ти Эс санхүүгийн программыг ашиглаж байна. Санхүүгийн программ нь Сангийн яаманд хүлээн зөвшөөрөгдсөн, төсвийн байгууллагын онцлогт тохирсон данс, бүртгэлийн системтэй бөгөөд УСНББОУС, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлд нийцсэн иж бүрэн санхүүгийн тайланг бэлтгэхэд ашиглаж байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Булган аймгийн Баян-агт сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 141,274.7 мянган төгрөгөөр бууран байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	5,818.7	81,560.2	75,741.5
Авлага	243,487.09	138,428.1	105,058.9
Бараа материал	166,910.6	214,373.9	47,463.3
Үндсэн хөрөнгө	940,338.7	902,504.4	37,834.3
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,356,555.2</b>	<b>1,336,866.7</b>	<b>-19,688.5</b>
Өглөг	17,217.9	3,336.2	13881.7
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	307,097.1	307,097.1	0.0
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>1,356,555.2</b>	<b>1,336,866.7</b>	<b>-19,668.5</b>

Тайлант онд орон нутгийн төсвөөс 82,993.8 мянган төгрөгийн санхүүжилт авсан ба ЭМДЕГ-аас 1,269,149.4 мянган төгрөгний санхүүжилт, Булган аймгийн ЭМГ-аас 19,163.9 мянган төгрөг (вакцины нөхөн шивэлт), оны эхний үлдэгдэл 5,818.7 мянган төгрөг нийт 1,427,572.1 мянган төгрөгийн санхүүжилтийг авч 1,353,188.1 мянган төгрөгийн зарцуулалт хийгдэж 81,560.2 мянган төгрөгийн дансны үлдэгдэлтэй гарсан байна.

Мөн тайлант онд авлага урд оныхоос 105,058.9 мянган төгрөгөөр буурсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 214,373.9 мянган төгрөг болж 2024 оноос 47,463.3 мянган төгрөгөөр өссөн байна. Бараа материалын хувьд 203,771.2 мянган төгрөгийн худалдан авалт хийж, 19,163.9 мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлэн орлогод авч 172,796.7 мянган төгрөгийн материалыг зарцуулсан байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг ЭМДСангаас 1,302,365.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн ба байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 102,268.3 мянган төгрөгөөр төлөвлөн орон нутгийн төрийн санд хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн санал 2025 онд 30,200.0 төгрөгөөр бууруулж 1,269,149.3 мянган төгрөгийн санхүүжилтийг авсан ч өр үүсгэлгүй үйл ажиллагааг явуулсан байна. Энэ нь ЭМДСангийн санхүүжилт буурсантай холбоотой байна.

#### **3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Баян-Агт сумын ЭМТөв нь гүйцэтгэлийн санхүүжилтээр санхүүжиж 1 хөтөлбөр 4 зориулалт арга хэмжээний хүрээнд 1,474,825.1 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөж гүйцэтгэлээр 1,269,149.3 мянган төгрөгийн санхүүжилтийг ЭМДСангаас авч, дээд шатнаас 2,064.6 мянган төгрөгийн санхүүжилтийг авсан байна. Орон нутгийн урсгал зардлыг санхүүжүүлэхээр 1 хөтөлбөр 1 зориулалт арга хэмжээний зардалд 83,793.8 мянган төгрөгийг төсөвлөж 82,993.8 мянган төгрөгийн санхүүжилтийг аван зарцуулсан байна.

### *Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
<b>71602-Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ</b>					
1.1	80302-Нэг иргэн	878,106.1	726,015.3	152,090.8	82.6
1.2	81603- Үндсэн тусламж	353,364.4	299,779.4	53,585.2	84.8
1.3	83603-Дээд шатнаас хуваарилсан	243,354.6	243,354.5	0.1	99.9
1.4	83602-Зг болон ЗД-ын нөөц хөрөнгөөс хуваарилсан	0.0	0.0		
<b>ОРОН НУТАГ УРСГАЛ САНХҮҮЖИЛТ</b>					
1.1	80111-Төрийн өмчийн байгууллагын тогтмол зардал	83,793.8	65,981.9	17,811.9	78.4

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Тайлант онд салбарын хэмжээнд нэмэлт санхүүжилтийн дансыг хаасан бөгөөд нэмэлт санхүүжилтийн дансаар ажил гүйлгээ хийгдээгүй, аваагүй болно.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

2025 онд гадаад, дотоодын эх үүсвэрээр ямар нэгэн төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

### 3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант оны худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд зааснаар гэрээ шууд байгуулан ажилласан ба энэ нь Засгийн газрын 2024 оны 1 сарын 3-ны 02 дугаар тогтоолоор баталсан босго үнийг баримталсан.

Булган аймгийн Баян-Агт сумын ЭМТөв нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 203,771.3 мянган төгрөгийн бараа материал, 42,600.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан байна.

Тайлант онд эмийн зардалд батлагдсан төсвөөс 79,478.5 мянган төгрөгийн эм эмнэлгийн хэрэгсэл, ороох боох материалыг худалдан авсан ба цахим худалдан авалтыг шууд гэрээгээр хийсэн байна. Цахим худалдан авалтыг хийгээгүй шалтгаан нь цахим худалдан авалт хийх нөхцөл нь бүрдээгүй тус ЭМТөв нь 2025 оны 01 сарын 15-аас эхлэн удаа дараа нийт 5 удаагийн албан тоот холбогдох баримт, утсаар хэд хэдэн удаа, Any desk-ээр 2 удаа холбогдсон боловч нэвтэрч чадаагүй байна.

Худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэр, төрөл	Төрөл	Төсөвт өртөг (мян.төг)	Гэрээ байгуулсан дүн	Гэрээ байгуулсан этгээдийн нэр
Бичиг хэргийн зардал	Бараа	8,377,6	2,937.0	Ондоо принт ХХК, Хөх дэл түшиг ХХК,
Тээвэр шатахууны зардал	Бараа	49,329.5	48,472.7	Петровис ХХК,
Тавилга	Бараа	5,000.0	2,760.0	, Хантүм глобал ХХК
Багаж техник хэрэгсэл	Бараа	29,576,8	7,100.0	МедбуянХХК, ОД ДАРЬЯА САН, Медклийн ХХК

Урсгал засвар	Бараа	37,018,5	31,565.7	М.Суранхар, Б.Энхбат, Тунгалаг, Р.Эрдэнэбаяр, Ариунсан, Б.Бүжидмаа
<b>Дүн</b>		<b>129,302.4</b>	<b>92,835.4</b>	

### 3.6 Үндэсний аудитын газраас ирүүлсэн ерөнхий чиглэлийн хүрээнд авсан судалгааны үр дүнгийн талаар:

- Байгууллагын даргын тушаалаар 5.0 мянган төгрөгөөр хоолны мөнгө тооцон олгож байна.
- Гадаад томилолт тухайн байгууллагад байхгүй.
- Төрд учирсан хохирлыг ббарагдуулахтай холбоотой гарсан зардал тайлант онд үүсээгүй.
- Тус газар нь тайлант онд бараа ажил үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөг shilendans.gov.mn цахим хуудсанд байршуулсан.
- Санхүүгийн программ хангамж нь 450.0 мянган төгрөгийн “Си-Ти-Эс” ХХК-тай гэрээ хийж ашигладаг
- 2025 онд орон тооны цомхотгол хийгдээгүй болно.

Ерөнхий чиглэлийн хүрээнд авсан судалгааны үр дүнд илсэн зөрчилтэй асуудлуудыг аудитын тайланд тусгасан болно.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Булган аймгийн Баян-агт сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах Төсвийг зохистой удирдаж, зориулалтын дагуу зарцуулах, эд хариуцагчтай хөдөлмөрийн гэрээ байгуулах талаар болон Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Бэйкер тилли Далайван аудит” ХХК-ийн Орхон аймаг дахь салбарын аудитор Б.Пүрэвсүрэн гүйцэтгэж анхан шатны чанарын хяналтыг салбарын захирал, аудитор Д.Мягмарсүрэн, хоёр дахь шатны чанарын хяналтыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Ж.Энхцоодол, газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Батцогт нар хэрэгжүүлэв.

Булган аймгийн Баян-агт сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 01 дугаар албан бичгээр ирүүлсэн байна

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр өмнөх оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн 1,245,796.0 мянган төгрөгийн нийт зардлаас 2 хувиар тогтоож сонгосон суурь үзүүлэлтээс тооцож 24,915.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн

материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 17,441.1 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 29 асуудлаар хяналтыг хэрэгжүүлэхэд зөрчилтэй асуудал гараагүй. Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тухайн байгууллага 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.2, 12.1.3 дахь заалтууд, 15 дугаар зүйлийн 15.1.2- 15.1.7 дахь заалтуудад заасан хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй байна.

##### **Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд авсан судалгааны үр дүн:**

Төрийн хэмнэлтийн хүрээнд автомашин, орлогч дарга, цахим худалдан авалттай холбоотой судалгаа авахад автомашин хэрэглэдэггүй, орлогч дарга ажиллуулаагүй, цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй, худалдан авалттай зөрчилтэй асуудал гараагүй.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Булган аймгийн Баян-агт сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны шилэн дансны нэгдсэн цахим хуудасны мэдээллээс дараах мэдээллийг түүвэрлэн шалгахад шалгалаа. Үүнд:

- Тендерт шалгарсан болон шалгараагүй талаарх товч мэдээлэл
- Цалингийн зардлаас бусад 5,000.0 мянган төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ
- Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээлэл

##### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Тус байгууллагын худалдан авах ажиллагааны баримт материалыг хянаж үзэхэд худалдан авах ажиллагаанд харьцуулалтын аргыг ашиглан бага үнийн санал ирүүлсэн байгууллагуудтай гэрээ хийж бараа материалыг худалдан авсан ба алдаа зөрчилтэй асуудал илрээгүй байна.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Булган аймгийн Баян-агт сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдсэн болно.

Санхүүгийн тайлангийн аудит хийхэд баримтлах ерөнхий бодлого, чиглэлийн дагуу Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, үндсэн хөрөнгө, бараа материалын биет тооллого, төсвийн орлого, зардлын зарцуулалттай холбоотой асуудлыг хянахаар тусгайлан авч үзсэн.

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Булган аймгийн Баян-агт сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдсэн болно. Дараах асуудлаар зөвлөмж өгсөн байна.

- Үндсэн хөрөнгийн элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн тэг үлдэгдэлтэй хөрөнгө дахин үнэлээгүй.
- Нийгмийн даатгалын тайланд цалин дутуу тайлагнасан.
- Бараа материалын дансанд хүнсний үлдэгдэл биетээр байхгүй.

Завсрын аудитаар зөвлөмжийг өгсөн бөгөөд биелэлтийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянан үзэхэд биелэлт хангасан байна.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар 4,072.0 мянган төгрөгийн 2 акт, материаллаг бус 3 зөвлөмж өгсөн байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		/мянган төгрөгөөр/ Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	4,072.0	2	2,070.6	100%
Зөвлөмж	3	-	2		100%
<b>Нийт дүн</b>	<b>5</b>	<b>4,072.0</b>	<b>4</b>	<b>2,070.6</b>	<b>100%</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитаар илэрсэн зөвлөмж болон хүргүүлсэн асуудлуудын хэрэгжилт, худалдан авах ажиллагааны гэрээ, тендэр шалгаруулалт зэргийг анхаарч ажиллах хэрэгтэй гэж үзэж байна.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 110,119.7 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрснээс 1,334.1 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 108,785.7 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

Аудитаар зөрчилтэй асуудал нь 1,334.1 мянган төгрөгийн санхүүгийн тайланд нөлөөлөх магадлалгүй тул материаллаг багатай гэж үзэн өөрчлөлтгүй дүгнэлт өгсөн болно.

#### 5.1 Төлбөрийн акт

- **Илрүүлэлт:** Эм тариа болон хүнсний материалын орлого зарлагын гүйлгээг тухай бүрт нь хийгээгүй явцын аудитаар биет тооллого хийн орлого зарлагыг шахахад 152.3 мянган төгрөгийн хүнсний материал, 181.2 мянган төгрөгийн эм тариа дутагдалтай байгаа нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх" 41 дүгээр зүйлийн 41.2.7. "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах" 5 дугаар зүйлийн 5.1.3."санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх" Нягтлан бодох бүртгэлийн 5 дугаар зүйлийн 5.1.4."үнэн зөв байх"; 5.1.5."хэмжигдэхүйц байх" гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.
- **Илрүүлэлт:** Булган аймгийн эрүүл мэндийн газрын даргын 2025 оны 09 сарын 19-ний өдрийн А/70 тоот эрх зүйн үндэслэлгүй тушаалаар сумын ЭМТ-ийн статистикч 1 000.5 мянган төгрөгийн урамшууллыг улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулан олгосон нь Засгийн газрын

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын 3.2. "Улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг эрүүл мэндийн ажилтны ажлын үр дүн, гүйцэтгэлийг үндэслэн үндсэн цалингийн 10-20 хувиар сар бүр тооцож, улирал тутам олгоно", Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-д "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах" 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дүгээр зүйлийн 15.1.3."хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" гэж заасныг зөрчсөн байна

## 5.2 Албан шаардлага

Албан шаардлага хүргүүлээгүй байна.

## 5.3 Зөвлөмж

### 1. Зардлын данстай холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Тайлангийн хугацаанд тус эмнэлэгийн нярав солигдсон байна. Санхүүгийн ажилтан солигдоход ажил хүлээлцэх тушаал гарсан боловч тооллого тооцоо хийж хөрөнгө өр төлбөрийг хүлээлгэж өгөөгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1."Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", 12 дугаар зүйлийн 12.2.2 "эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед" хөрөнгө өр төлбөрийн тооллогыг заавал хийнэ" гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Өгсөн зөвлөмж:** Холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах.

### 2. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн тэг үлдэгдэлтэй 108.785.6 мянган төгрөгийн анхны өртөгтэй 75 нэр төрлийн 212 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3."холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолын 7 дугаар зүйлийн 7.1-д "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ." гэсэн заалт зөрчигдөж байна.

**Өгсөн зөвлөмж:** Холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах.

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5.Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ гэж заасны дагуу аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж ажиллах ажлын төлөвлөгөөг боловсруулан 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 06 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Ажил хүлээлцсэн акт байхгүй	1	0.0					1	0.0				
Бараа материалын үлдэгдэл дутуу	1	333.6	1	333.5								
Цалин илүү олгосон	1	1,000.5	1	1,000.5								
Тэг үлдэгдэлтэй хөрөнгө	1	108,785.7					1	108,785.7				
Дүн	4	110,119.8	2	1,334.1			2	108,785.7				